



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/АМ

Булган сум

Иж бүрэн хүлэмжийг хүлээн авах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны II/04 дүгээр тогтоолын 2.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 241017/05-804 дугаар "Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл (Булган) хүлэмж нийлүүлэх гэрээ"-ний хүрээнд нийлүүлж буй 153,300,000 (нэг зуун тавин гурван сая гурван зуун мянга) төгрөгийн үнэ бүхий 23 ширхэг иж бүрэн хүлэмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)  
Б.Лхамаа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)  
М.Лхагваням ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Л.Наранчимэг ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн менежер)

2. Дээрх хүлэмжийг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, Орон нутгийн өмчид бүртгэн, холбогдох баримт бичиг бүрдүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Засахирамж

6324011069